## ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА СУНГАХ ХҮСЭЛТ ИЛГЭЭХ ЗААВАР

- **Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах хүсэлтийг тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө www.tzmoh.gov.mn бүртгэл, зөвшөөрлийн цахим хуудсаар илгээнэ.**
- **Цахим хуудаст байгууллагын тоон гарын үсгээр нэвтрэх ба тоон гарын үсэг олгох зөвшөөрөлтэй байгууллагаас тоон гарын үсэг авна.** /татвар, нийгмийн даатгалын системд нэвтрэх тоон гарын үсгээр нэвтрэх боломжгүй тул шинээр авна/
- **Хүсэлт илгээхтэй холбоотой тодруулах зүйлийг 77990101(1), 75116420 дугаарын утаснаас лавлана уу.**

**Бүрдүүлэх материал:**

1. Албан хүсэлт
2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
3. Компанийн дүрмийн хуулбар
4. Эмийн аюулгүй байдлын мэдээ /зөвхөн эмийн санд хамаарна/
5. Эрүүл мэндийн ажилтны үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн диплом, лицензийн хуулбар
6. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан /сүүлийн 3 жилээр/
7. Аж ахуйн нэгжийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт
8. Үйл ажиллагааны тайлан /www.tailan.ubhealth.mn хаягаар илгээдэг жилийн эцсийн тайлан, сүүлийн 3 жилээр/

Хувийн ортой эмнэлэг, клиник, сувилал:

- Хувийн эмнэлгийн үйл ажиллагааны тайлан ЭМТ-202
- Сувиллын байгууллагын үйл ажиллагааны тайлан ЭМТ-203
- БЗДХ-ын кабинетийн үйл ажиллагааны тайланг ЭМТ-305
- Нүүр амны кабинетийн үйл ажиллагааны тайлан ЭМТ-309
- Арьсны кабинетийн үйл ажиллагааны тайлан ЭМТ-312

Эмийн сан нь үйл ажиллагааны тайланг хувийн эмнэлгийн үйл ажиллагааны тайлангийн ЭМТ-201.27-1, 2, 3 маягтаар өгнө. Үүнд:

- 201.27.1- Хүлээн авсан жорын тоо, төрлөөр
- 201.27.2- Борлуулалтын орлого
- 201.27.3 – Эмийн нөөцийн тайлан

9. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
10. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт
11. Эмнэлэг, эмийн сан, АШМУХҮ-ний ажлын байр үйлчилгээний зориулалттай үл хөдлөхийн гэрчилгээтэй байх

| № | Үйлчилгээний төрөл, чиглэл | Мөнгөн дүн | Эрх зүйн үндэслэл | Төлбөр төлөх заавар |
|---|---|---|---|---|
| 1 | Эмнэлэг, сувилал | 120.000 төгрөг | Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4, 35 дугаар зүйлийн 35.1.1, 42 дугаар зүйлийн 42.4 дэх хэсэг | НЭМГ-ын Төрийн сангийн **100200020401** дансанд тушаана /Гүйлгээний утга хэсэгт хуулийн |
| 2 | Эмчилгээний гоо засал | 200.000 төгрөг | Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 42 дугаар зүйлийн 42.4 дэх хэсэг | |
| 3 | Эмийн сан | 44.000 | Улсын тэмдэгтийн хураамжийн | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | төгрөг | тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 42 дугаар зүйлийн 42.4 дэх хэсэг | этгээдийн нэр, регистрийн дугаарыг бичих/ |
| 4 | Ахуйн шавж, мэрэгч устгал, халдваргүйжүүлэх үйлчилгээ | 20.000 төгрөг | Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3, 42 дугаар зүйлийн 42.4 дэх хэсэг | |